



ИРГЭНИЙ НИСЭХИЙН  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2023 оны 08 сарын 14 өдөр

Дугаар АБЧЗ

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Холбоо навигаци, ажиглалтын албанд ISO 27001:2013 олон улсын стандартыг нэвтрүүлэхэд шаардлагатай зөвлөх үйлчилгээ" үзүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны  
дарга:

Ч.Чулуунхүү

(Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа  
Холбоо, навигаци, ажиглалтын албаны  
Аюулгүй ажиллагаа, чанарын удирдлагын  
хэсгийн дарга)

Гишүүд:

Г.Цэвээнгэрэл

(Иргэний нисэхийн үндэсний төвийн  
Мэдээллийн аюулгүй байдал, технологийн  
албаны дарга)

Д.Оюундулам

("ХУД Яармаг" Төрийн бус байгууллагын  
гишүүн (тохиролцсоноор))

О.Баярсайхан

("Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв"  
Төрийн бус байгууллагын гишүүн  
(тохиролцсоноор))

Нарийн бичгийн  
дарга:

Ч.Ганзориг

(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө  
оруулалт, захиалагчийн албаны Худалдан  
авах ажиллагааны тасгийн мэргэжилтэн)

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Ч.Чулуунхүү)-нд, тушаалын хэрэгжилтэд

2. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Ч.Чулуунхүү)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3. Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ч.Ганзориг)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА